

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20.. оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох
зээлийн хүүгийн дээд хэмжээ”-г тогтоох тухай

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувиар тогтоосугай.
2. Энэ тогтоолоор баталсан зээлийн хүүгийн дээд хэмжээг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдэд үүрэг болгосугай..

ДАРГА

Н.ХҮДЭРЧУЛУУН

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20.. оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн, барьцааны, батлан
даалтын гэрээний ерөнхий загвар”-ыг батлах тухай

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн гэрээний ерөнхий загварыг нэгдүгээр, барьцааны гэрээний ерөнхий загварыг хоёрдугаар, батлан даалтын гэрээний ерөнхий загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолоор баталсан зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загварыг мөнгөн зээлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөхийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ХҮДЭРЧУЛУУН

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20.. оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох
зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлал”-ыг батлах тухай

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.3,
Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн
үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн хэмжээг
бодох, тооцох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох
зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлал”-ыг мөнгөн зээлийн үйл ажиллагаанд
дагаж мөрдөхийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ХҮДЭРЧУЛУУН



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХ НЬ



БОЛОВСРУУЛСАН:

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЗАХ ЗЭЭЛ, СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ГАЗАР
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА
СЭЗИС-ИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТ, СУДАЛГАА ХАРИУЦСАН ПРОРЕКТОР Б.МӨНХЗАЯА**

2023 ОН

АГУУЛГА

ОРШИЛ.....	3
МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮҮ ТОГТООХ НЬ.....	4
ОЛОН УЛСЫН МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	7
МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛ ОЛГОГЧ САЛБАРУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	10
МОНГОЛ УЛСЫН ХУВЬД МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХ НЬ.....	16
МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМНЫ ИБАЛАНС СИТЕМД ИЛГЭЭСЭН ЦАХИМ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ.....	17
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	19
ДҮГНЭЛТ.....	21
ЭХ СУРВАЛЖ	24

ОРШИЛ

Уламжлалт банкны үйлчилгээ авах боломжгүй иргэдэд богино хугацааны зээл олгоход барьцаалан зээлдүүлэх газрууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагууд хувийн эд зүйлсийг барьцаанд тавьж, үнэлэгдсэн үнээр нь зээл олгодог. Барьцаалан зээлдүүлэх газар, зээлийн үйлчилгээг тойрсон нэг анхаарал татахуйц асуудал бол эдгээр зээлээс ихэвчлэн өндөр хүү авдаг явдал юм.

Барьцаалан зээлдүүлэх газарт түшиглэдэг олон хүмүүсийн санхүүгийн эмзэг байдлыг харгалзан зээлийн хүүг зохицуулах нь чухал асуудал болж байна. Барьцаалан зээлдүүлэх газар, зээлийн үйлчилгээний зээлийн хүүг зохицуулах үндэслэл нь хэрэглэгчдийг зээл олгох хулгайн үйлдлээс хамгаалах шаардлагаас үүдэлтэй.

Мэдээж зээлдэгчдэд яаралтай бэлэн мөнгө хэрэгтэй байгаа тохиолдолд тэд зээлийн таагүй нөхцөл, тэр дундаа хэт өндөр хүүг хүлээн авахад бэлэн байж болно. Энэ нь өрийн мөчлөг, санхүүгийн тогтворгүй байдалд хүргэж, эцэстээ эмзэг бүлгийн хүмүүсийн санхүүгийн хүндрэлийг улам даамжруулдаг. Зээлийн хүүтэй холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлснээр засгийн газрууд шударга зээлийн практикийг дэмжих, ломбардын салбар дахь мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх зорилготой.

Олон улс орон хүүгийн дээд хязгаарыг тогтоож, хэт их хүүгийн төлбөр болон зээлийн хулгайн үйлдлээс хэрэглэгчдийг хамгаалдаг. Эдгээр дээд хязгаар нь зээлийн хэмжээ, хугацаа эсвэл тухайн улсын ерөнхий зохицуулалт зэрэг хүчин зүйлээс хамаарч өөр өөр байдаг. Харин Монгол Улсын хувьд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.2-т Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох гэж хуульчилсан.

Иймд энэхүү судалгаагаар нэр бүхий 7 орныг сонгон ломбардын үйл ажиллагааны хууль эрх зүй зохицуулалтын орчин, дотоодын зээл олгогч салбаруудын өнөөгийн байдал тоон мэдээлэл дээр үндэслэн зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох санал, зөвлөмжийг боловсруулахыг зорилоо. Судалгаанд холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрдэм шинжилгээний судалгаа, зохицуулалтын байгууллага, салбарын тайлан мэдээ зэрэг мэдээлэл цуглуулж чанарын болон тоон аргыг хослуулан ашигласан болно.

Судалгаанд мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүү тогтоох тухай үндэслэл, шаардлага, аргачлал, олон улсын мөнгөн зээлийн үйл ажиллагааны зохицуулалтын хууль эрх зүйн орчин, зээлийн хүүгийн таазны хэмжээ, түүнчлэн Монгол улсын санхүүгийн зах зээл дээрх зээл олгогч салбаруудын өнөөгийн байдлыг судалж харьцуулж мөнгөн зээлийн үйл ажиллагааны боломжит хүүгийн дээд хэмжээг гаргасан билээ. Эцэст нь хувь судлаачийн зүгээс дүгнэлт зөвлөмжийг оруулсан.

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮҮ ТОГТООХ НЬ

Барьцаалан зээлдүүлэх газар, зээлийн үйлчилгээ нь бэлэн мөнгөний хомсдолд орсон банк, банк бус санхүүгийн байгууллагуудын зээл авах шаардлага хангахгүй зээл хүсэгчийн хөдлөх хөрөнгийг үндсэндээ зах зээлийн буюу түүнээс доогуур үнэ цэнээр үнэлж хүлээн авч, хөдлөх хөрөнгө эзэмшигчид үүний үнэ цэний тодорхой хувийг мөнгө болгон өндөр зээлийн хүүтэй зээлдэг. Энэ зээлийн дүн нь барьцаалан зээлдүүлэх газрын (зах зээлийн эсвэл материаллаг) үнээс тухайн зүйлийг дахин худалдан авах эрхийн үнийг хассан гэсэн үг юм.

Техникийн талаас нь авч үзвэл харилцагч банкны зээлийн нэгэн адил зээлийн хүү төлдөг бөгөөд ихэвчлэн хадгалалтын барьцааны үнийн дүнгийн тодорхой тогтмол дүн эсвэл тодорхой хувийг төлдөг. Зээлийн хүүг төлж барагдуулаагүй эсвэл зээлийн төлбөрийг хамгийн дээд хугацаа өнгөрсний дараа төлж барагдуулаагүй тохиолдолд зээлдэгч хөдлөх хөрөнгөө эргүүлэн авах эрхээ алдаж, барьцаалан зээлдүүлэх газрууд тухайн зүйлийг олон нийтэд худалдах эрхийг авна. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны гүйлгээ нь зардлыг нөхөх ашиг олох зорилготой.

Зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох нь хэд хэдэн чухал үндэслэл, зорилготой. Үүнд:

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах: Зээлийн хүүгийн дээд хязгаарыг ихэвчлэн зээлийн хүүгийн дарамт, хэт их хүүгээс хэрэглэгчдийг хамгаалах зорилгоор тавьдаг. Зээлдүүлэгчид хүүгийн дээд хязгааргүй бол өрийн зангилаа, санхүүгийн тогтворгүй байдал, эмзэг бүлгийн хувь хүн эсвэл олон нийтийн мөлжлөгт хүргэж болзошгүй хэт өндөр хүү ногдуулдаг. Хүүгийн дээд хязгаар нь зээлийн шударга, боломжийн нөхцөлийг хангаж, зээлдэгчийг шударга бус үйлдлээс хамгаалахад тусалдаг.

Боломжийн зээлийн хүртээмж: Зээлийн хүүг хязгаарласнаар зээлдэгчид боломжийн нөхцөлөөр зээл авах боломж бүрдэж, хүүгийн хэт их зардалд дарамт учруулахгүйгээр санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжтой болно.

Санхүүгийн тогтвортой байдал: Зээлийн хүүгийн өндөр түвшин нь зээлдэгчийн санхүүгийн тогтворгүй байдалд нөлөөлж, өрийн мөчлөг болон болзошгүй төлбөрийн чадваргүй болоход хүргэдэг. Зээлийн хүүгийн дээд хязгаар нь зээлдэгчийг өрийн дарамтад дарагдахаас сэргийлж санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад тусалдаг. Зээлийн хүүгийн дээд хязгаар нь зээлдэгчийн санхүүгийн хямралд орох эрсдэлийг бууруулж, хариуцлагатай зээлийн практикийг дэмжинэ.

Эдийн засгийн өсөлт ба бүтээмж: Зээлдэгчдийг боломжийн үнэтэй зээлээр хангах боломжийг хангаснаар иргэд, аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийх, бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэх, үр ашигтай эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломжтой. Хүртээмжтэй зээл нь бизнес эрхлэх, ажлын байр бий болгох, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд тусалдаг.

Зохицуулалтын тогтолцоо ба ил тод байдал: Зээлийн хүүгийн дээд хязгаарыг хэрэгжүүлэх нь ил тод, урьдчилан таамаглах боломжтой зээлийн орчныг бүрдүүлэхэд туслах зохицуулалтын тогтолцоог бүрдүүлдэг. Энэ нь зээлдүүлэгчдийн хувьд тодорхой хил хязгаар, удирдамжийг тогтоож, шударга, зохицуулалттай хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг баталгаажуулдаг. Зээлийн хүүгийн дээд хязгаар нь ил тод байдлыг дэмжиж, зүй бусаар зээл олгох үйлдлүүдийг бууруулах замаар санхүүгийн системийн ерөнхий тогтвортой байдал, бүрэн бүтэн байдалд хувь нэмэр оруулдаг.

Манай улсад арилжааны банкнуудыг Монгол банкнаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос хянан зохицуулдаг.

Харин барьцаалан зээлдүүлэх газруудад дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсээс зөвшөөрөл өгөх ба хуулийн хэрэгжилтэд цагдаагийн байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газар гэх мэт байгууллагууд хяналт тавьдаг.

Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталж, хуулийн хэрэгжилтийг 2023 оны 3 дугаар сарын 01 -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуульд заасан шаардлагыг хангасан, аймагт 100 000 000 төгрөг, түүнээс дээш, нийслэлд 300 000 000 төгрөг, түүнээс дээш хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээдийг Санхүүгийн зохицуулах хороо хяналт зохицуулалт тавихаар хуульчилсан.

Монголын арилжааны банкнуудын хувьд зээлийн хүүгээ дараах байдлаар тогтоодог байна¹.

Зээлийн хүү = Эх үүсвэр (хадгаламжийн хүү) + Үйл ажиллагааны зардал + Эрсдэлийн сан+Заавал байлгах нөөц* + Ашиг**

*Монголбанкны журмаар банкнууд төгрөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө 8.5%, валютынхаа 15.0 хувийг заавал байлгах нөөц /ЗБН/ хэлбэрээр МБ-ны харилцах дансанд хүүгүй байршуулдаг.

** Банкнууд активынхаа нэг хувьтай тэнцэх хэмжээний ашиг олох зорилгоор зээлийн суурь хүүг тогтоохдоо ашгийн хувиа нэмдэг.

Банк бус санхүүгийн байгууллагууд болон хадгаламж зээлийн хоршооны хувьд банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 -т Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй гэж заасныг баримталдаг байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хувьд Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг баталсан. 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Барьцаалан зээлдүүлэх газар нь Зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний хүүгийн хэмжээг сарын 3 (гурав) хувиас, алдангийн хэмжээг өдрийн 0.2 хувиас хэтрүүлэхгүй тооцох бөгөөд барьцаа хөрөнгийг зарж борлуулахгүй байхаар тогтоож уг зохицуулалт 2020 оны 12 дугаар сарын 22-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хамааруулсан бөгөөд дахин сунгаагүй. Уг тогтоолын хэрэгжилт, хүүгийн хэмжээнд хязгаар тавьсан нөлөөллийн талаар судалгаа мэдээлэл байхгүй байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд тусгаснаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл ажиллах бөгөөд бүрэлдэхүүнд нь Монголбанк, СЗХ, Сангийн яам, Хууль зүйн яам, ШӨХТГ, цагдаа, МҮХАҮТ-ийн төлөөлөл орно. Энэ зөвлөлөөс мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүүгийн дээд хэмжээг тогтоох гэж заасан. Одоогоор мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүүгийн дээд хэмжээг тогтоогоогүй байна.

Зээлийн хүүгийн дээд хэмжээ нь зээлдэгчид хүүгийн огцом өсөлтөөс хамгаалж, зээлийн хүүгийн зардлын дээд хязгаарыг бий болгодог. Хязгаар нь өөрөөр хэлбэл зээлийн хугацааны туршид хүү хэчнээн их өсөхөөс үл хамааран зээлийн хүү урьдчилж тогтоосон хүүгийн хязгаараас хэзээ ч хэтрэхгүй гэсэн үг юм.

¹ <https://ikon.mn/opinion/1k7e>

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хязгаарыг тооцоолох онолын ерөнхий аргыг энд тусгая.

- Жишиг хүүг тодорхойлох: Хүүгийн дээд хязгаар нь ихэвчлэн төв банкнаас тогтоосон жишиг хүү эсвэл зах зээлийн дундаж хүү гэх мэт жишиг хүүнд суурилдаг.
- Маржин нэмэх: Маржин нь зээлдүүлэгчийн зардал, эрсдэл, ашгийн хэмжээ зэрэг хүчин зүйлсийг тооцдог нэмэлт хувь буюу тогтмол дүнг илэрхийлнэ.
- Дээд хэмжээг тооцоолох: Жишиг хүү болон маржинг олсны дараа зээлийн хүүгийн дээд хэмжээг тооцоолж болно. Дээд хэмжээг олохын тулд жишиг хүү дээр зөрүүг нэмнэ.


Зээлийн хүүгийн дээд хязгаар = Лавлагаа хүү + Маржин

Хүүгийн дээд хязгаар нь санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэх зорилготой хэдий ч тодорхой нөхцөлд санхүүгийн оролцоонд хүсээгүй үр дагаварт хүргэж болзошгүй. Дээд хязгаар нь жилийн дээд хязгаарыг бий болгосны дараа шинээр олгох зээлийн хүүгийн бус шимтгэлийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд хүргэж болно. Зээлийн өсөлт нэмэгдэж байгаатай холбогдуулан барьцаалан зээлдүүлэх газрууд жижиг зээлдэгчдийн зардлаар том зээлдэгчдийг онилох тул жижиг зээлдэгчид тэр даруй буурах боломжтой. Тэд өөрсдийн үйл ажиллагаа, санхүүжилтийн зардлыг бууруулж, үйлчлүүлэгчийн баазад тулгуурлан үйл ажиллагаагаа өргөтгөнө.

ОЛОН УЛСЫН МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Барьцаалан зээлдүүлэх газар Хятадад 3000 жилийн өмнө мөнгөн зээлийн үйлчилгээний зарчмаар ажилладаг байгууллага байсан гэх мэдээлэл эртний Грек, Ромын эх сурвалжид байдаг байна.

Дэлхийн мөнгөн зээлийн үйл ажиллагааны зах зээлийн хэмжээ 2022 онд 38,773.6 сая доллароор үнэлэгдэж байсан бөгөөд 2030 он гэхэд 47,133.42 сая ам.долларт хүрч, 2023-2030 он хүртэл жилийн нийлмэл өсөлтийн хувь нь 3.02 хувиар өсөх төлөвтэй байна².



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа бол дэлхийн хэмжээнд түгээмэл байдаг.

Тухайлбал АНУ-д 12,000 гаруй барьцаалан зээлдүүлэх газрууд байдаг. Энэтхэгт Мумбайд төвтэй бие даасан зөвлөх компани болох Commtrendz Risk Management Services компанийн захирал Гнанасекар Тиagaraжанын хэлснээр бараг бүх гудамжинд “барьцаалан зээлдүүлэх газар” байдаг. Тайландад мөнгөн зээлийн үйл ажиллагааны гурван том сүлжээ

нь Ngern Tid Lor, Srisawad, Muang Thai Capital (MTC) бөгөөд тэд бараг 10,000 гүйлгээний оффис ажиллуулдаг. Олон нийтийн аюулгүй байдлын яамны мэдээлснээр Вьетнамд 2022 оны эцсээр 27,000 орчим барьцаалан зээлдүүлэх газрууд ажиллаж байсан.

Улс орнууд уламжлалт банкны зээлд хамрагдах боломжгүй хүмүүст боломжийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлдэгчийг өрийн дарамтад дарагдахаас сэргийлэх, мөнгө хүүлэлтийг зогсоох зорилгоор зээлийн хүүгийн хязгаарлалтын бодлого баримталж байна. Тухайлбал:

Япон³: Япон улс 1983 оны 5 дугаар сарын 13-ны өдөр 5 бүлэгтэй “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бизнесийн тухай хууль”-ийг баталсан.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хязгаарыг “Мөнгө олгох хяналтын тухай хууль”-иар тогтоосон.

Хүүгийн хувь хэмжээг хязгаарлах тухай хуульд зээлийн хүүгийн дээд хэмжээг зээлийн хэмжээнээс харгалзуулан дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- (i) үндсэн зээлийн хэмжээ 100,000 иенээс бага бол жилийн 20 хувь;
- (ii) үндсэн зээлийн хэмжээ 100,000-1,000,000 иений хооронд бол жилийн 18 хувь;
- (iii) үндсэн зээлийн хэмжээ 1,000,000 иен ба түүнээс дээш бол жилийн 15 хувь байна.

Мөн мөнгөн зээлийн үйлчилгээ үзүүлэгч этгээд нь хураамж авах гэрээ байгуулах ёсгүй, зуучлалд заасан мөнгөн дүнгийн 5 хувиас давсан шимтгэлийг авах ёсгүй. Бүх нэмэлт төлбөрийг оруулаад дээд тал нь 20 хувь байна.

Сингапур⁴: Сингапур улсын хууль зүйн яам нь мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулдаг. Барьцаалан зээлдүүлэгчдийн болон зээлийн үйлчилгээний тухай 2015 оны хуульд

² <https://www.marketwatch.com/press-release/pawn-shop-market-2023-2030-size-share-growth-and-business-opportunity-and-outlook-2023-04-20>

³ https://d-arch.ide.go.jp/je_archive/society/wp_je_unu59.html

⁴ <https://maxi-cash.com/pawnbrokers-in-singapore/>

(Pawnbrokers Act 2015) мөн барьцаалан зээлдүүлэх газрын болон зээлийн үйлчилгээний тухай 2015 оны дүрэмд (Pawnbrokers Rules 2015) барьцаалан зээлдүүлэх газрыг байгуулах, ажиллуулах, тэдгээрийн ногдуулах хураамжийг тогтоодог эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар заасан байдаг. Сингапурт Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээ сарын 1.5 хувиас хэтрэхгүй буюу жилийн 18 хувь байна. Хүүгийн төлбөрийг сар бүр эсвэл хэсэгчлэн төлж болно.

Хүүгийн тооцооллын томьёо: (Хүүтэй төлбөр) = (Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хэмжээ) x (Зээл авах сарын тоо) x 1.50%

Сингапур дахь барьцаалан зээлдүүлэгчдийн зээлийн хүүгээс гадна үйлчилгээний хураамж, хадгалалтын хураамж гэх мэт бусад хураамж авч болох боловч эдгээр нь үндэслэлтэй байх ёстой бөгөөд урьдчилж ил болгох ёстой.

Сингапур дахь зээлийн үйлчилгээ үзүүлэгчид зээлдэгчдэд зээлийн дэлгэрэнгүй мэдээлэл, түүний дотор зээлсэн дүн, хүү, хураамжийн хэмжээг агуулсан мөнгөн зээлдүүлэх үйл ажиллагааны тасалбар өгдөг. Мөн энэ тасалбар нь барьцааны зүйлийн талаар тайлбар, тооцоолсон үнэ зэрэг мэдээллийг агуулсан байх ёстой.

Нидерланд⁵: Нидерланд Улсын Хэрэглэгч болон зах зээлийн газар (Netherlands Authority for Consumers and Markets) мөнгөн зээлийн үйл ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж ажилладаг.

2014 онд батлагдсан “Нидерландын мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай акт”-аар иргэдийн мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлд төлөх хүүгийн дээд хязгаарыг тогтоосон. Акт батлагдсан өдрөөс мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлд сарын дээд тал нь 9 хувийн хүүтэй байсан бол 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн энэ дээд хэмжээ сарын 4.5 хувь болгож бууруулсан. (Энэ нь мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүх зээлд хамаарна.) Түүнчлэн мөнгөн зээлийн үйл ажиллагааны гэрээний хугацааг 2 сараас доошгүй байхаар журамласан. Хэрэглэгч энэ хугацаанд барьцаа хөрөнгөө буцаан авах эрхтэй. Хэрэв тохиролцсон зээлийн хугацааг сунгах боломжгүй бол хэрэглэгчдэд энэ тухай (болон бусад нөхцөл) урьдчилан мэдэгдэх ёстой. Мөн актаар мөнгөн зээлийн үйл ажиллагааны гэрээнд тавигдах бусад шаардлагыг тогтоожээ. Жишээлбэл, гэрээнд хэрэглэгчид ямар хэмжээний төлбөр, хэзээ төлөх ёстойг мэдэхэд шаардлагатай мэдээллийг агуулсан байх ёстой.

БНХАУ: 2003 оны 7 дугаар сард БНХАУ-ын засгийн газраас мөнгөн зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Худалдааны яамыг байгуулсан. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг жигдрүүлэх, хяналт, менежментийг тогтолцоог сайжруулах, энэ салбарын хөгжлийг дэмжих зорилгоор 2005 оны 2 дугаар сард БНХАУ-ын Худалдааны яамнаас Мөнгөн зээлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг баталсан.

Хятадын мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүүг 3 аргаар тооцож болно.

1. Тохиролцсон жилийн хүү 24 хувиас хэтрэхгүй бол хоёр талын тохиролцсон хүүгийн дагуу тооцно.

2. Тохиролцсон жилийн хүү 24 хувь-36 хувь байвал зээлдэгч нь төлөөгүй бол энэ хүрээнд хүү төлөхгүй, төлсөн хүүг буцаан олгохгүй.

3. Хэрэв тохиролцсон жилийн хүү 36 хувиас хэтэрсэн бол зээлдэгч нь урьд нь төлсөн бол илүү хүүг буцаан олгохыг зээлдүүлэгчээс шаардаж болно.

⁵ <https://www.acm.nl/en/publications/publication/13079/New-regulations-on-pawnshops-set-ceilings-on-interest-rates-on-pawn-loans>

Шинэ Зеланд: Шинэ Зеландын Санхүүгийн зах зээлийн газар нь 2013 онд Санхүүгийн зах зээлд дагаж мөрдөх ёс зүйн актыг баталсан.

Тус улсын засгийн газар нь мөнгө хүүлэгчдээс иргэдээ хамгаалах зорилгоор өндөр өртөгтэй богино хугацааны зээлд шинэ зохицуулалт хийсэн. Энэ нь зээлийн хүүг үндсэн дүнгээс 2 дахин их байж болохгүй гэсэн хатуу зохицуулалтыг Зээлийн гэрээний тухай хуульд нэмэлтээр оруулсан. Жишээлбэл, 500 ам.доллар зээлсэн бол зээлийн хугацаа дуусахад 1000 ам.доллаароос дээш мөнгө төлөхгүй гэсэн үг юм. Түүнчлэн Засгийн газраас Хэрэглээний зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулж зээлийн хүүд өдрийн 0.8 хувь байхаар дээд хэмжээ тогтоосон.

Өмнөд Африк: Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хязгаарыг Үндэсний Зээлийн хуулиар зохицуулдаг. ҮЗХ нь зээлийн хүү, хариуцлагатай зээлийн үйл ажиллагаа, хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой дүрэм журам, шаардлагыг тогтоодог. Зээлийн хүүгийн дээд хязгаар нь зээлийн гэрээний төрөл болон зээлийн хэмжээнээс хамаарч өөр өөр байж болно. Өмнөд Африк дахь барьцаалан зээлдүүлэх газрууд Зээлийн үйлчилгээ үзүүлэгч (Credit Providers) хэсэгт ордог.

Зээлийн жижиг гүйлгээ: Мөнгөн зээлийн үйл ажиллагааны гүйлгээг багтаасан жижиг зээлийн гүйлгээний хувьд Үндэсний Зээлийн хуулиар (NCA) дээд тал нь сард 5 хувь (жилд 60%) хүү тогтоодог. Энэ дээд хязгаар нь R8,000 хүртэлх зээлд хамаарна.

АНУ:

АНУ муж бүр тусдаа өөрсдийн иргэдэд тааруулсан хуультай байдаг. Түүнтэй адилаар мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулахаар муж бүр өөрсдийн гэсэн хүүгийн дээд хэмжээтэй байдаг. Доорх хүснэгтээс мужуудын хүүгийн дээд хэмжээн харуулсан болно.

№	Мужийн нэр	Хүүгийн дээд хэмжээ (сараар)	№	Мужийн нэр	Хүүгийн дээд хэмжээ (сараар)	№	Мужийн нэр	Хүүгийн дээд хэмжээ (сараар)
1	Алабама	25%	14	Кентакки	2.00%	27	Хойд Каролина	2.00%
2	Аляска	20%	15	Луизиана	10.00%	28	Охайо	5.00%
3	Аризона	8%	16	Майн	25.00%	29	Оклахома	20.00%
4	Калифорни	2.50%	17	Массачусетс	3.00%	30	Орегон	3.00%
5	Коннектикут	3.00%	18	Мичиган	3.00%	31	Пенсильвани	2.50%
6	ДиСи	5.00%	19	Миннесота	3.00%	32	Род Айленд	5.00%
7	Делавэр	3.00%	20	Миссисипи	25.00%	33	Теннесси	2.00%
8	Флорида	25.00%	21	Миссури	2.00%	34	Юта	10.00%
9	Жиоржиа	25.00%	22	Монтана	25.00%	35	Вермонт	3.00%
10	Хавай	10.00%	23	Невада	10.00%	36	Виржиниа	5.00%
11	Иллинойс	3.00%	24	Нью Жерси	4.00%	37	Вашингтон	3.00%
12	Индиана	3.00%	25	Шинэ Мексик	10.00%	38	Висконсин	3.00%
13	Канзас	10.00%	26	Нью Йорк	4.00%	39	Вайоминг	20.00%

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛ ОЛГОГЧ САЛБАРУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол банкнаас 2022 онд гүйцэтгэсэн Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох түүвэр судалгаанд Монгол улсын 15-69 насны 1947 иргэн хамрагджээ. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 36.0 хувь нь Улаанбаатар хотоос, 64.0 хувь нь орон нутгийн 20 аймгийн иргэд байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 67.5 хувь нь “Ямар нэгэн байдлаар хоол хүнс болон бусад хэрэгцээгээ хангахад санхүүгийн асуудал тулгардаг тул хэн нэгнээс мөнгө зээлдэг” гэжээ. Мөн түүнчлэн тэдгээр иргэдийн 71.4 хувь буюу 3 хүн тутмын 2 нь ямар нэгэн байдлаар зээлтэй байгаагаас 21.7 хувь 1 хүртэлх сарын орлоготой нь тэнцэх хэмжээний, 23.5 хувь нь 2-12 сарын орлоготой нь дүйцэхүйц, 26.2 хувь нь 12 сарын орлогоос нь илүү зээлтэй байна. Эдгээр зээлтэй хүний 28.2 хувь нь сүүлийн 12 сарын дотор 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар зээлийн эргэн төлөлтөө хоцроожээ.


Энэхүү судалгаагаар зээл олгогч байгууллагаас авсан зээлийн төрлийг дараах байдлаар ангилсан байна⁶.

Зээлийн төрөл	Хувь, хэмжээ
Ипотекийн зээл	25.5%
Банкны зээл	45.3%
ББСБ-ын зээл	20.4%
Цахим зээл	25.6%
Хувь хүмүүсээс авсан зээл	34.2%
Барьцаалан зээлдүүлэх газар болон өдрийн зээлийн үйлчилгээ	26.1%

Дээрх хүснэгтэд хувь хүмүүсээс авсан зээл, барьцаалан зээлдүүлэх газар болон өдрийн зээлийн үйлчилгээний хувь хэмжээ өндөр байгаа нь тэдний зээл олгоход тавих шаардлага нь банк, банк бус санхүүгийн байгууллагуудаас хялбар болохыг илтгэнэ. Ийм учраас зээлийн хүртээмж бага, ажилгүй, тогтмол орлогогүй, тэтгэвэрт гарсан, оюутан гэх мэт иргэдэд эрэлт хэрэгцээтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ болж байна.

Монгол улсын санхүүгийн салбарт зээлийн үйлчилгээг арилжааны банк, ББСБ, ХЗХ болон барьцаалан зээлдүүлэх газрууд үзүүлж байна.

Банкны салбар




Банкны системийн нийт актив 2023 оны I улиралд 451.0 тэрбум төгрөгөөр өсөж, 46,402.5 тэрбум төгрөгт хүрсэн. Активын өөрчлөлтийг данс тус бүрээр харвал гадаад актив 1,162.3 тэрбум, дотоодын цэвэр зээл 875.1 тэрбум төгрөгөөр өссөн, банкны нөөц 939.5 тэрбум төгрөг, ТБҮЦ 567.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. 2023 оны I улирлын эцсийн байдлаар нийт активын 45.6 хувийг дотоодын цэвэр зээл бүрдүүлж байгаа нь өмнөх улирлаас 1.5 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.

⁶ Монгол банк, 2022 он, Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны эхний улирлын байдлаар 23.2 их наяд төгрөг болжээ. Үүний 54.0 хувийг иргэдийн зээл эзэлж байна.

Үзүүлэлт	Эхний улирал			Өөрчлөлт (+/-)	
	2021	2022	2023	2023/2022	
				Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	17,636.4	22,086.6	23,230.8	1,144.2	5.2
-Хэвийн зээл	14,333.2	18,992.8	19,621.7	628.9	3.3
-Хугацаа хэтэрсэн зээл	1,282.5	969.3	1,383.6	414.3	42.7
-Чанаргүй зээл	2,020.7	2,124.5	2,225.6	101.1	4.8
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	11.5	9.6	9.6	-	-
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	7.3	4.4	6.0	-	-



Нийт зээлийн 84.5 хувийг хэвийн зээл, 9.6 хувийг чанаргүй зээл, 6.0 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.



Хэмжих нэгж: хувь

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол банк



2023 оны 1 дүгээр улирлын байдлаар шинээр олгосон нийт зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 16.1 хувьтай байна. Шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар өсөж жилийн 16.7 хувьд хүрчээ.



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-ны салбарын хэмжээнд 31,248 зээлдэгчийн 212.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 0.38 пунктээр буурсан үзүүлэлтэй. ХЗХ-оос олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.3 хувь байна.



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн салбар

2019 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт бизнес регистрийн бүртгэлтэй 3,164 барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас 1,594 идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байжээ.

Харин Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны мэдээллээр манай улсад 1,000 орчим барьцаалан зээлдүүлэх газар байгаагаас 872 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг. Эдгээр барьцаалан зээлдүүлэх газраар жилд дунджаар 2.5 сая хүн үйлчлүүлдэг гэх албан бус статистик байна⁷.

Дээрх тоо баримтаас харахад улсын хэмжээнд 1,000 гаран барьцаалан зээлдүүлэгч байгаа гэх ч Татварын Ерөнхий Газрын тоо баримтаар 2020 оны 2 дугаар сарын байдлаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа ажиллуулдаг 294 татвар төлөгч 33.5 тэрбум төгрөгийн борлуулалтаасаа 2.5 тэрбумын татвар төлсөн байна⁸ гэжээ.


Монгол улсын иргэний хуульд “Ломбард болон зээлийн үйлчилгээнд зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаалан зээл гаргана.” гэж заасан бөгөөд өөрөөр хэлбэл үнэт эдлэл, цахилгаан бараа, автомашин болон хөдлөх хөрөнгө барьцаалсан лизинг гэх мэт төрлийн зээл олгодог.

⁷ <https://news.mn/r/2601593/>

⁸ <https://ikon.mn/n/2hbj>



Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газраас боловсруулсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээ тогтоохтой холбогдуулан хийсэн зээлийн хүүгийн судалгаа”-д дурдсанаар:

2023 оны 7 дугаар сарын 01-ний байдлаар “Үүлэн технологи” ХХК-ийн бүтээсэн procreditor.mn (мэргэжлийн зээлдэгч) програмыг Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 280 хуулийн этгээд түүний 173 салбар нэгж, 54 зээлийн үйлчилгээ үзүүлэгч идэвхтэй ашиглаж байна. Тус програмд 2023 оны 7 дугаар сарын 01-ний байдлаар бүртгэгдсэн 245,570 зээлдэгчийн 257.3 тэрбум төгрөгийн зээлийн багцын төлөв дараах байдалтай байна.



Procreditor.mn мэргэжлийн зээлдэгч програмыг ашигладаг барьцаалан зээлдүүлэх газар болон зээлийн үйлчилгээ үзүүлэгчийн олгосон нийт зээлийн 62.6 хувийг 15-30 хоногтой, 28.4 хувийг 30-аас дээш хоногтой, 7 хувийг 8-14 хоногтой, 2 хувийг 1-7 хоногийн зээл тус тус эзэлж байна.

Тус програмд бүртгэлтэй 245,570 зээлдэгчийн 39.3 хувь нь 100,000-300,000 төгрөгийн, 18.2 хувь нь 300,000-500,000 төгрөгийн, 13.6 хувь нь 500,000-1,000,000 төгрөгийн, 12.8 хувь нь 50,000-100,000 төгрөгийн, 9.6 хувь нь 1,000,000-5,000,000 төгрөгийн, 4.8 хувь нь 5,000-50,000 төгрөгийн, 1.7 хувь нь 5,000,000 төгрөгөөс дээш хэмжээтэй зээл авчээ.




нутагт 5.1 хувь байна⁹.

Зээлийн хүүг нийт олгосон зээлийн багцтай харьцуулбал нийт зээлийн багцын 31.6 хувийг 2-4 хувийн хүүтэй, 58.1 хувийг 5-7 хувийн хүүтэй, 10.3 хувийг 7-с дээш хувийн хүүтэй зээл эзэлж байна.

Нийт зээлийн багцын жигнэсэн дундаж хүү 6.1 хувь, үүнээс Улаанбаатар хотод 6.2 хувь, орон

⁹ СЗХ, Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээ тогтоохтой холбогдуулан хийсэн зээлийн хүүгийн судалгаа

Улаанбаатар хотод нийт 220.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсоноос 41.5 хувь буюу 91.7 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, орон нутаг нийт 35.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсоноос 25.5 хувь буюу 9.1 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн үзүүлэлттэй.



Дээр дурдсан мэдээллээс дүгнэхэд ломбард, зээлийн үйлчилгээ нь Монголын санхүүгийн салбарын салшгүй хэсэг болсон байна.

Зээл олгогч салбаруудын зээлийн хүүгийн хэмжээг харахад Банк, банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хүү зах зээлийнхээ жамаар эх үүсвэрийн хүү, зээлдэгчийн эрсдэлийн түвшинтэй уялдан тогтож байгаа нь түүний зээлийн хүүгийн өсөлт өсөж, буурч байгаагаар тайлбарлагдана.

Харин барьцаалан зээлдүүлэгч газар, зээлийн үйлчилгээнүүдийн зээлийн сарын хүү маш өндөр хэлбэлзэлтэй 2-24 хувь буюу жилийн 24-288 хувь байгаа нь зээлийн үзэмжээс хамааруулж олгодог түүнчлэн төрөөс тавих хяналт шалгалт сул байна гэж үзэхээр байна.

Мөн судлаачдын багаас цахим хуудаснаас нэр бүхий 10 гаран барьцаалан зээлдэх газрын утсыг олж холбогдон мэдээлэл авахад 500,000 хүртэл төгрөг зээлбэл 7 хоногийн 5 хувь, 14 хоногийн 8 хувийн хүүтэй зээл олгоно гэсэн мэдээлэл өгсөн нь зээлийн хүү нь хэт өндөр байгааг харуулж байна. Энэ нь барьцаа хөрөнгийн үнэ болон үйлчлүүлэгчийн төлбөрийн чадвараас хэтэрсэн зардал болж зээлдэгчдийг хүүгийн дарамтад оруулж, эд хөрөнгөө алдахад хүргэх мөнгө хүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУВЬД МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХ НЬ

Бичил санхүүгийн зах зээлд ББСБ болон ХЗХ зээлийн үйлчилгээ үзүүлдэг. 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар Улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 514 ББСБ, 191 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Эдгээр байгууллагуудын 2021, 2022, 2023 он тус бүрийн 1 дүгээр улирлын зээлийн хүүгийн дээд хязгаарыг итгэлцлийн интервал байгуулан тооцоход дараах байдалтай байна. Үүнд:

Утга	ХЗХ хүүгийн дээд хязгаар /сараар/			ББСБ хүүгийн дээд хязгаар /сараар/		
	90%	95%	99%	90%	95%	99%
Итгэх түвшин						
2021.01	4.68%	4.95%	5.46%	6.23%	6.85%	8.04%
2022.01	4.53%	4.79%	5.27%	6.20%	6.78%	7.91%
2023.01	4.53%	4.79%	5.28%	6.24%	6.77%	7.81%


Тус хүснэгтээс харахад ХЗХ болон ББСБ-ын зээлийн хүүгийн дээд хязгаар нь хоорондоо зөрүүтэй харагдаж байна. Үүний шалтгаан нь ХЗХ бол өөрийн гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд бол ББСБ бол жижиг, дунд бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн хэрэгцээг хангах үүднээс үйлчилгээнүүд үзүүлдэг ашгийн төлөө байгууллага юм. Тиймээс барьцаалан зээлдүүлэх газар нь ББСБ-тэй төстэй үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө байгууллага тул ББСБ-уудын зээлийн хүүгийн дээд хязгаарыг мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүүгийн дээд хэмжээтэй дүйцүүлэн тооцох нь тохиромжтой гэж үзлээ.

ББСБ-уудын хүүгийн дээд хязгаарыг 95 хувийн итгэх түвшинд тооцоход зээлийн дээд хүү нь 2021 оны 1 дүгээр улиралд 6.85 хувь, 2022 оны 1 дүгээр улиралд 6.78 хувь, 2023 оны 1 дүгээр улиралд 6.77 хувь тус тус байна. Үүнээс харахад 3 жилийн зээлийн дээд хүү нь дунджаар **6.8% хувь** байна. Энэхүү үзүүлэлт (6.8%) нь дээр дурдсанчлан барьцаалан зээлдүүлэх газруудын зээлийн багцын жигнэсэн дундаж хүү 6.1 хувьтай ойролцоо байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан барьцаалан зээлдүүлэх газруудын нийт зээлийн багцад сарын 3-7 хувийн хүүтэй зээл нь 84.7 хувийг эзэлдэг.

Иймд барьцаалан зээлдүүлэх газруудын зээлийн багцын жигнэсэн дундаж хүү болон ББСБ-уудын зээлийн хүүгийн дээд хязгаарыг итгэлцлийн интервал байгуулан тооцсон дүнд үндэслэн зах зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын **6.8%** хувиар тогтоох нь тохиромжтой гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМНЫ ИБАЛАНС СИТЕМД ИЛГЭЭСЭН ЦАХИМ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ


Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсээс 2023 оны хагас жилийн байдлаар нийслэлийн 9 дүүрэгт барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг идэвхтэй эрхэлж байгаа хуулийн этгээдийн судалгааг хийхэд төв түүний салбар нэгж давхардсан байдлаар нийт 410 барьцаалан зээлдүүлэх газар (БЗГ) бүртгэгдсэн. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны орон нутагт дахь төлөөлөгч болох Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүдээр 2023 оны хагас жилийн байдлаар барьцаалан зээлдүүлэх үйд ажиллагааг идэвхтэй эрхэлж буй БЗГ-ын судалгааг хийлгэхэд 214 БЗГ бүртгэгдсэн тоо баримт байна. Тус судалгаагаар давхардсан тоогоор 624 БЗГ бүртгэгдсэн байгаагаас 443 БЗГ түүний 181 салбар нэгж бүртгэгдсэн.



Дээрх судалгаанд хамрагдсан 443 БЗГ-ын Сангийн яамны И-баланс системд илгээсэн сүүлийн 5 жилийн байдлаарх цахим санхүүгийн тайланд шинжилгээ хийхэд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо 2021-2022 онд буурсан үзүүлэлттэй байна.


Судалгаанд хамрагдсан БЗГ-уудын ашигт ажиллагааны түвшинг 2018-2022 оны жилийн эцсийн байдлаарх санхүүгийн тайлангаас тооцож үзэхэд сүүлийн 5 жилд тогтмол өссөн байна.

Тухайлбал, Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй БЗГ-уудын өөрийн хөрөнгийн өгөөж 2018-2022 онд 20.0-27.27 хувь болон өссөн байх бөгөөд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй БЗГ-уудын өөрийн хөрөнгийн өгөөж Улаанбаатар хотод байрлах БЗГ-уудынхаас дунджаар 0.5 хувиар өндөр байгаа нь ажиглагдаж байна. Судалгаанд хамрагдсан БЗГ-ууд нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 27.01 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан байна.



Эх сурвалж: И-баланс цахим санхүүгийн тайлан

Сангийн яамны И-баланс системд илгээсэн цахим тайлангаас үзэхэд 2018 онд 377 БЗГ-ын 30 буюу 7.9 хувь нь, 2019 онд 403 БЗГ-ын 25 буюу 6.2 хувь нь, 2020 онд 409 БЗГ-ын 55 буюу 13.4 хувь нь, 2021 онд 313 БЗГ-ын 59 буюу 18.8 хувь нь, 2022 онд 314 БЗГ-ын 43 буюу 13.6 хувь нь алдагдалтай ажилласан байх бөгөөд алдагдалтай ажилласан БЗГ-ын тоо коронавируст цар тахалтай 2020-2021 онд өссөн, 2022 оноос буурах төлөвтэй байна.



Эх сурвалж: И-баланс цахим санхүүгийн тайлан

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Зээлийн хүүгийн дээд хязгаарыг тооцоолох онолын ерөнхий аргачлал нь жишиг хүүг тогтоож маржин нэмэх юм.

- Жишиг хүүг тодорхойлох: Хүүгийн дээд хязгаар нь ихэвчлэн төв банкнаас тогтоосон жишиг хүү эсвэл зах зээлийн дундаж хүү гэх мэт жишиг хүүнд суурилдаг.
- Маржин нэмэх: Маржин нь зээлдүүлэгчийн зардал, эрсдэл, ашгийн хэмжээ зэрэг хүчин зүйлсийг тооцдог нэмэлт хувь буюу тогтмол дүнг илэрхийлнэ.
- Дээд хэмжээг тооцоолох: Жишиг хүү болон маржинг олсны дараа зээлийн хүүгийн дээд хэмжээг тооцоолж болно.

Монгол Улсын хувьд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, нэгдсэн бүртгэл тодорхойгүй, үүний улмаас нийт зээлийн хэжээ, чанаргүй зээлийн хэмжээ, эрсдэлийн зардал, үйл ажиллагааны зардал, ашгийн хэмжээ зэрэг хүчин зүйлсийг тодорхой тооцоолох боломжгүй нөхцөл байдалтай байна. Иймд тус судалгаанд улс орнуудын хүүгийн дээд хязгаарыг банкны зээлийн хүүтэй жиших, эрсдэлийн шагнал тогтоосон хувь хэмжээг тодорхойлох аргачлалыг сонгосон болно.

Сингапур, Канад, Эстони, Малайз, Намиби зэрэг орнуудад мөнгөн зээлийн үйл ажиллагаа (pawnbroker, pawn shop) -даа зээлийн хүүний дээд хязгаарыг жилийн 18.0-36.0 хувь байхаар тогтоосон байна.

Эдгээр улс орнуудын хувьд банкны зээлийн хүүний эрсдэлийн шагнал 1.63-3.75 хувь байгаа бол мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүүний эрсдэлийн шагнал 14.75-30.00 хувь байна. Мөн мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүний дээд хязгаарыг банкны зээлийн хүүтэй харьцуулан үзвэл банкны зээлийн хүүг 3.1-5.6 дахин нэмэгдүүлэх замаар мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүний дээд хязгаарыг тогтоосон байна.

№	Улсын нэр	Суурь хүү	Банкны зээлийн хүү	МЗҮА хүүний дээд хязгаар	Инфляц	Бодит хүү F=C-E	Банкны зээлийн хүүний эрсдэлийн шагнал G=C-B	МЗ хүүний эрсдэлийн шагнал H=D-B	МЗ хүү/банкны зээлийн хүү I=D/C
	A	B	C	D	E	F	G	H	I
1	Сингапур ¹⁰	3.25%	5.25%	18.00%	4.70%	0.55%	2.00%	14.75%	3.4
2	Канад ¹¹	5.00%	7.20%	35.00%	3.10%	4.10%	2.20%	30.00%	4.9
3	Эстони ¹²	7.10%	6.39%	36.00%	4.90%	1.49%	-0.71%	28.90%	5.6
4	Малайз ¹³	2.40%	5.43%	24.00%	1.80%	3.63%	3.03%	21.60%	4.4
5	Намиби	7.75%	11.50%	36.00%	6.03%	5.47%	3.75%	28.25%	3.1
6	Монгол Улс	13.0%	17.0%	-	7.9%	9.1%	4.0%	-	-
	Ave	5.10%	7.15%	29.80%	4.11%	3.05%	2.05%	24.70%	4.3
	Median	5.00%	6.39%	35.00%	4.70%	3.63%	2.20%	28.25%	4.4
	Stdev	2.33%	2.55%	8.32%	1.66%	2.00%	1.70%	6.46%	1.0
	Max	7.75%	11.50%	36.00%	6.03%	5.47%	3.75%	30.00%	5.6
	Min	2.40%	5.25%	18.00%	1.80%	0.55%	-0.71%	14.75%	3.1

¹⁰ <https://sso.agc.gov.sg/Act/PA2015>

¹¹ <https://www.gazette.gc.ca/rp-pr/p1/2023/2023-12-23/html/reg3-eng.html>

¹² <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/Riigikogu/act/527102023001/consolide>

¹³ http://www.commonlii.org/my/legis/consol_act/pa1972152/

Доорх хүснэгтэд Монгол Улсын хувьд мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтооходоо банкны зээлийн хүүг 2-5 дахин нэмэгдүүлсэн, эрсдэлийн шагналыг 15-70 хувь байх хувилбаруудыг тооцож үзлээ.

№	Хувилбарууд	МЗҮА-ны зээлийн хүүний хязгаар (жилээр)	Сарын хүү
1	Банкны зээлийн хүүнээс 2 дахин их	34%	2.83%
2	Банкны зээлийн хүүнээс 3 дахин их	51%	4.25%
3	Банкны зээлийн хүүнээс 4 дахин их	68%	5.66%
4	Банкны зээлийн хүүнээс 5 дахин их	85%	7.08%
5	Суурь хүү + 15% эрсдэлийн шагнал	28.00%	2.33%
6	Суурь хүү + 20% эрсдэлийн шагнал	33.00%	2.75%
7	Суурь хүү + 25% эрсдэлийн шагнал	38.00%	3.17%
8	Суурь хүү + 30% эрсдэлийн шагнал	43.00%	3.58%
9	Суурь хүү + 40% эрсдэлийн шагнал	53.00%	4.42%
10	Суурь хүү + 50% эрсдэлийн шагнал	63.00%	5.25%
11	Суурь хүү + 60% эрсдэлийн шагнал	73.00%	6.08%
12	Суурь хүү + 70% эрсдэлийн шагнал	83.00%	6.92%
	Ave	48.11%	4.01%
	Median	43.00%	3.58%
	Stdev	18.54%	1.54%
	Max	85.00%	7.08%
	Min	28.00%	2.33%

Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг дунджаар банкны зээлийн хүүг 4.3 дахин нэмэгдүүлсэн, эрсдэлийн шагналыг 24.7 хувиар тооцон тогтоосон байгаа нь харагдаж байна.

БЗГ-уудаас авсан зээлийн хүүгийн талаарх асуулгаар Улаанбаатар хотод сарын 6-8 хувийн, орон нутагт сарын 8-10 хувийн хүүтэй зээлийг олгож байна. Хэрэв барьцаалан зээлдэх газраас олгох зээлийн хүүгийн хэмжээ дунджаар 7 хувь гэж үзвэл банкны зээлийн хүүг 5 дахин нэмэгдүүлсэн, эрсдэлийн шагналыг 71.9 хувиар нэмэгдүүлсэн зээлийн хүү одоогийн зах зээлд тогтсон гэж үзэх үндэслэлтэй байна.

№	Улсын нэр	Суурь хүү	Банкны зээлийн хүү	Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүүний дээд хязгаар	Инфляц	Бодит хүү G=D-F	Банкны зээлийн хүүний эрсдэлийн шагнал H=D-C	Мөнгөн зээлийн хүүний эрсдэлийн шагнал I=E-C	МЗ хүү/Банкны зээлийн хүү J=E/D
	A	C	D	E	F	G	H	I	J
I	Монгол	13.00%	17.00%	84.96%	8.60%	8.40%	4.00%	71.96%	5.0
	Ave	13.00%	17.00%	84.96%	8.60%	8.40%	4.00%	71.96%	5.0
	Median	13.00%	17.00%	84.96%	8.60%	8.40%	4.00%	71.96%	5.0
	Stdev	13.00%	17.00%	84.96%	8.60%	8.40%	4.00%	-13.00%	(0.7)
	Max	13.00%	17.00%	84.96%	8.60%	8.40%	4.00%	71.96%	5.0
	Min	13.00%	17.00%	84.96%	8.60%	8.40%	4.00%	71.96%	5.0

Монгол Улсын хувьд БЗГ-ууд нь хулгай, гэмт хэрэгт холбогдолтой эд зүйлсийг барьцаанд авах, үнэт эдлэлийн сорьц, орцын хэмжээг бодитой тогтоох боломжгүй зэрэг хүндрэлтэй байдлаас үүдэх эрсдэл нэлээд элбэг тохиолддог байдлыг харгалзан үзэж банкны зээлийн хүүг 4 дахин нэмэгдүүлсэн, эрсдэлийн шагналыг 40 хувь байхаар тооцсон хувилбараар мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох нь тохиромжтой байна.

ДҮГНЭЛТ

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын зээл олгогч салбарын салшгүй хэсэг, орлого багатай иргэдийн амьдралын төлөв байдлыг илтгэх нэгэн индикатор болжээ.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар зээлийн жигнэсэн дундаж сарын хүү банк 1.4 хувь, ББСБ 3.3 хувь, ХЗХ 2.2 хувь байна. Харин барьцаалан зээлдүүлэх газрууд болон зээлийн үйлчилгээний сарын хүү 2-24 хувь буюу өндөр хэлбэлзэлтэй, зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 6.1 хувь байна. Мөн “прокредитор” програмд бүртгэгдсэн 245,570 зээлдэгчийн 257.3 тэрбум төгрөгийн зээлийн багцын 89.7 хувь нь 7 хүртэлх хувийн хүүтэй, 10.3 хувь нь 7-с дээш хувийн хүүтэй олгогдсон байна.

Монгол Улсын хэмжээнд зээл олгогч салбаруудын 2022 оны жилийн эцсийн байдлаарх ашигт ажиллагааг өөрийн хөрөнгийн өгөөжөөр тооцож үзвэл банкны салбар 23 хувийн, ББСБ-ын салбар 14 хувийн, хадгаламж зээлийн хоршоо 25 хувийн, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчид 27 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан байна.

Дээр дурдсан мэдээллээс манай улсын санхүүгийн зах зээл дээр зээл олгогч салбаруудын зээлийн сарын жигнэсэн дундаж хүү болон ашигт ажиллагааны түвшин түүний зөрүүг харж болно.

Бенчмарк - Бусад хөгжингүй болон хөгжиж буй орнуудын мөнгөн зээлийн үйл ажиллагаанд тогтоосон зээлийн хүүгийн дээд хэмжээг тухайн орны банкны зээлийн хүүтэй жишихэд дунджаар 4.3 дахин нэмэгдүүлсэн, суурь хүү дээр дунджаар 24.7 хувийн эрсдэлийн шагнал нэмж тооцсон байна.

БЗГ-уудаас авсан зээлийн хүүгийн талаарх асуулгаар Улаанбаатар хотод сарын 6-8 хувийн, орон нутагт сарын 8-10 хувийн хүүтэй зээлийг олгож байх бөгөөд барьцаалан зээлдэх газраас олгох зээлийн хүүгийн хэмжээ дунджаар 7 хувь гэж үзвэл банкны зээлийн хүүг 5 дахин нэмэгдүүлсэн, 71.9 хувийн эрсдэлийн шагнал нэмэгдүүлсэн хүү зах зээлд тогтсон гэж үзэх болохоор байна.

Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийн ашиг ажиллагааны түвшин бусад зээл олгогч салбаруудтай харьцуулахад харьцангуй өндөр болон одоогийн зах зээл дээрх зээлийн хүүгийн хувь хэмжээ нь бусад улс орнуудын жишгээс өндөр тогтсон зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж одоо тогтсон зээлийн хүүгийн хувь хэмжээг бууруулах боломжтой гэж дүгнэж байна. Иймд мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хязгаарыг банкны зээлийн хүүг 4 дахин нэмэгдүүлсэн буюу жилийн 68 хувь (сарын 5.6 хувь), суурь хүүг 40 хувийн эрсдэлийн шагналаар нэмэгдүүлсэн буюу жилийн 53 хувь (сарын 4.4 хувь) байх саналыг дэвшүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд үндэслэн мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтооход анхаарвал зохих дараах зөвлөмжийг хүргэж байна:

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүүгийн дээд хязгаарын давуу тал:

1. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах: Зээлийн хүүгийн дээд хэмжээ нь зээлдэгчийг хэт их хүүгийн төлбөрөөс хамгаалж, зээлийн дээрмийн үйлдлээс урьдчилан сэргийлдэг. Дээд хэмжээ нь шударга, ил тод зээл олгохыг дэмжиж, хэрэглэгчдийг мөлжлөгөөс хамгаалдаг.

2. Бололцоо: Зээлийн хүүгийн дээд хэмжээ нь зээлдэгчид барьцаалан зээлдүүлэх газруудаас зээл авах зардлыг бололцоотой хэмжээнд төлөх боломжийг олгодог. Дээд хэмжээг тогтоосноор зээлдэгчид хүүгийн төлбөрөөс болж өрийн мөчлөгт баригдахаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг.

3. Стандартчилал: Хүүгийн дээд хэмжээ нь салбарын тогтвортой, жигд байдлыг хангадаг. Зээлдэгч нь өөр өөр барьцаалан зээлдүүлэх газруудыг зээлийн хүүд үндэслэн харьцуулж, мэдээлэлтэй шийдвэр гаргах, хамгийн таатай хувилбарыг сонгох боломжийг олгодог.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хүүгийн дээд хязгаарын сул тал:

1. Эрсдэлийн үнэлгээ: Зээлийн хүүгийн дээд хязгаар нь мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээл олгохтой холбоотой эрсдэлийг зохих ёсоор үнэлж, үнийг тогтоох боломжийг хязгаарлаж болзошгүй. Зээлийн хүүгийн дээд хязгаарыг бууруулснаар барьцаалан зээлдүүлэх газрууд өндөр эрсдэлтэй зээлдэгчид зээл олгох хүсэлгүй болж, хамгийн их хэрэгцээтэй хүмүүст зээл олгохоо багасгадаг.

2. Үйл ажиллагааны зардал: Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох нь барьцаалан зээлдүүлэх газрууд ашиг орлого, амьдрах чадварт нөлөөлж болзошгүй. Хэрэв дээд хязгаар хэтэрхий бага байвал мөнгөн зээлийн үйл ажиллагааны зардлаа нөхөх, тогтвортой ажиллахад хүндрэл учруулж, зах зээл дээрх үйлчилгээ багасах магадлалтай.

3. Уян хатан байдал буурна: Зээлийн хүүгийн дээд хэмжээ нь зах зээлийн нөхцөл байдал, зээлдэгчийн эрсдэл болон бусад хүчин зүйлд тулгуурлан зээлийн хүүг тогтоох уян хатан байдлыг хязгаарладаг. Энэ нь тэдний өөрчлөгдөж буй эдийн засгийн нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх чадварыг хязгаарлаж, хувь хэмжээгээ тохируулахад нь саад учруулах боломжтой.

Уг санал гаргасан үндэслэл:

1. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд барьцаалан зээлдүүлэх газар нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний хүүгийн хэмжээг сарын 3 (гурав) хувиас хэтрүүлэхгүй тооцох зохицуулалт үйлчилсэн. Хууль хэрэгжсэнээр нийгэм эдийн засаг, тус салбарт үүсэх нөлөөг харуулсан статистик мэдээлэл байхгүй байна.

2. Судалгаанд хамруулсан барьцаалан зээлдүүлэх газруудын нийт зээлийн багцад сарын 3-7 хувьтай зээл 89 орчим хувь эзэлж байна.

3. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар үйл ажиллагаа эрхэлж байгаа 514 ББСБ-ын сүүлийн 3 жилийн мөн үеийн зээлийн хүүгийн дээд хязгааруудыг 95 хувийн итгэх түвшинд тооцсон ба дээд хязгаарын хувиудыг дунджилж тооцоход судалгаанд хамруулсан барьцаалан зээлдүүлэх газруудын зээлийн багцын жигнэсэн дундаж хүүтэй нэлээд ойролцоо гарсан.

Гэхдээ энэ хүү бол барьцаалан зээлдүүлэх газруудын тоон мэдээлэл болон зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр тодорхойлогдож гарсан хүү биш юм.

Магадгүй Санхүүгийн зохицуулах хороо барьцаалан зээлдүүлэх газрууд болон зээлийн үйлчилгээнээс зах зээл дээр үйлчилж буй зээлийн хүүгийн мэдээллийг тогтмол авч эхэлснээр тухайн салбарын зээлийн хүүгийн сарын дээд хязгаарыг нэг, хоёр жилийн дараа шинэчлэх нь зөв болно гэж үзэж байна.

Түүнчлэн энэ үед инфляцын давамгайлсан түвшинг харгалзан үзэж, зээлийн хүүгийн дээд хязгаарыг тохируулан зээлдэгчийн худалдан авах чадвар болон инфляцын дарамт хоорондын тэнцвэрийг хадгалах нь зүйтэй.

Мөн зээлийн хүүгийн зохицуулалтын тууштай, тогтвортой байдлыг хангахын тулд төв банкнаас тогтоосон мөнгөний бодлого, тухайлбал жишиг хүү, мөнгөний бодлогыг зөөлрүүлэх, чангаруулах арга хэмжээг мөн харгалзан үзэх хэрэгтэй.

Мэдээж мөнгөн зээлийн үйл ажиллагаан дахь зээлийн хүүгийн зохицуулалт нь бусад зээлийн байгууллагатай харьцуулахад барьцаалан зээлдүүлэх газар, зээлийн үйлчилгээний барьцааны өвөрмөц онцлог, зээлийн хугацаа богино, эрсдэлийн өөр өөр шинж чанарыг харгалзан үздэгээр онцлог юм.

ЭХ СУРВАЛЖ

1. 2011-10-27 Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль
2. 2002-12-12 Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль
3. 2022-11-04 Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль
4. 2021-05-21 Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны хууль
5. 2020-04-29 Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
6. Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн салбарын тойм 2023 оны I улирал
7. Санхүүгийн зохицуулах хороо, Зээлийн хүүд тааз тогтоохоос үүдэх сөрөг нөлөөлөл судалгаа, 2019
8. Санхүүгийн зохицуулах хороо, Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоохтой холбогдуулан хийсэн зээлийн хүүгийн судалгаа, 2023 он
9. Монгол банк, Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа, 2022 он
10. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2023 он
11. Worldbank, (2022). Interest Rate Repression Around the World.
12. 2023-2029 оны Хятадын ломбардын аж үйлдвэрийн гүнзгийрүүлсэн судалгаа, хөгжлийн чиг хандлагын судалгааны тайлан
13. “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019 · 15, “Зээлийн хүүний дээд хязгаар тогтоох нь боловсон цэвэрлэгээ гэж үү?”
14. The Financing of Small and Medium Enterprise in China: A Case Study of China’s Pawn-broking Industry
15. <https://www.worldbank.org/en/topic/financialinclusion/brief/regulating-pawnshops>
16. <https://ikon.mn/opinion/1k7e>
17. https://en.wikipedia.org/wiki/Interest_rate_cap_and_floor
18. <http://www.news.mn>, Ломбардын хүү сарын 3 хувь болсноор хаалгаа барина
19. Pawn Shop Market Is Booming Worldwide | EZCorp, Pawngo, (openpr.com)
20. Pawn Shops Market Size, Share, Trends Analysis | Forecast (marketresearch.biz)
21. <http://www.legislation.govt.nz/act/public/2004/0070/latest/whole.html#DLM305180>
22. <https://www.police.govt.nz/advice-services/businesses-and-organisations/secondhand-dealers-and-pawnbrokers/pawnbrokers>
23. <https://www.ceicdata.com/en/indicator/japan/bank-lending-rate>
24. <https://www.icba.org/newsroom/news-and-articles/2023/01/27/ncua-extends-credit-union-interest-rate-ceiling>
25. <http://data.mofcom.gov.cn/list/zxtj/1/cateinfo.html>
26. http://pdf.dfcfw.com/pdf/H3_AP202007271394534617_1.pdf
27. <http://ltfzs.mofcom.gov.cn/article/date/201703/20170302537270.shtml>
28. <https://lawguide.co.za/south-african-credit-agreements/>
29. <https://www.bu.edu/rbfl/files/2013/09/Pawnshops-Behavioral-Economics-and-Self-Regulation.pdf>
30. <https://openknowledge.worldbank.org/server/api/core/bitstreams/db52e3ae-519a-587d-94b8-a40fbd69d822/content>
31. <https://www.wa.gov.au/system/files/2021-03/LRC-Project-081-Discussion-Paper.pdf>
32. <https://www.nbfira.org.bw/sites/default/files/Draft%20Pawnshop%20Regulations%20%20%2012062017Final.pdf>
33. <https://www.nationalpawnbrokers.org/pawn-shop-regulations/>

34. <https://www.adb.org/sites/default/files/publication/200141/sdwp-045.pdf>
35. <https://thehustle.co/the-unpredictable-economics-of-pawn-shops/>
36. <https://sff.ie/wp-content/uploads/2018/11/irr.pdf>
37. https://www.fca.org.uk/search-results?search_term=pawn%20shop%20cap%20rate
38. <http://www.fca.org.uk>